



**ОРХОН АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 10 сарын 21 өдөр

Дугаар А/79

Баян-Өндөр сум

Г Арга хэмжээ зохион байгуулж хөрөнгө Г  
гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Биеийн тамир спортын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 1.3 дахь заалт, Эрүүл мэндийн сайдын 2021 оны А/780 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. "ЭРҮҮЛ МЭНД-ЭКО ГОРОО" аялал зохион байгуулах удирдамжийг нэгдүгээр, шаардагдах төсвийг хоёрдугаар хавсралтаар баталсугай.
2. "ЭРҮҮЛ МЭНД-ЭКО ГОРОО" аяллыг удирдамжийн дагуу үр дүнтэй зохион байгуулахыг Нийгмийн эрүүл мэндийн төвийн ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг), Биеийн тамир чийрэгжүүлэлт, осол гэмтлийн тандалт хариуцсан мэргэжилтэн (А.Хонгорзул) нарт тус тус даалгасугай.
3. "ЭРҮҮЛ МЭНД-ЭКО ГОРОО" аялалд шаардагдах төсөв 250.000 (Хоёр зуун тавин мянга)-н төгрөгийг төсөл хөтөлбөр бараа үйлчилгээний бусад зардлаас гаргахыг салбарын санхүү бүртгэл, мэдээлэл, нягтлан бодохын ажилтан (Н.Чулуун-Эрдэнэ)-д зөвшөөрсүгэй.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Эрүүл мэндийн боловсрол сургалт сурталчилгаа хариуцсан ахлах мэргэжилтэн (А.Ганчимэг)-д даалгасугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 10 сарын 21  
өдрийн тоот тушаалын хавсралт



## "ЭРҮҮЛ МЭНД – ЭКО ГОРОО АЯЛАЛ"-ЫН УДИРДАМЖ

### ЗОРИЛГО:

Дэлхийн алхалтын өдрийг тэмдэглэн өнгөрүүлэх, олон нийтэд эерэг хандлага, эерэг сэтгэлгээг төлөвшүүлэх, нийтийн биеийн тамирыг хөгжүүлэх, иргэдийг эрүүл амьдралын хэв маягт уриалан дуудах, эрүүл чийрэг, эрч хүчтэй бие хүн болгон төлөвшүүлэх, хөдөлгөөн эрүүл мэндийг сурталчлах, байгаль орчноо хамгаалах, уламжлалт зан үйлээ танин мэдэх, уул овоогоо ариулан дээдэлж, хүндэтгэл үзүүлэхэд оршино.

### ХАМТРАН АЖИЛЛАХ БАЙГУУЛЛАГА:

- Баян-Өндөр сумын ЗДТГ
- Соёл урлаг, аялал жуулчлалын газар
- Бүсийн оношилгоо эмчилгээний төв
- Хутагт ламын Ганданшаддүвлин хийд
- Орхон аймгийн Явган алхалтын холбоо

### ХУГАЦАА:

2024 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 09:30 цагт Амарын талбайд цуглан 10:00 цагт маршрутын дагуу хөдөлнө.

### ХАМРАХ ХҮРЭЭ:

Аймгийн нийт иргэд, байгууллага, хамт олон

### ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА:

1. Эрүүл мэнд эко гороо аялал нь 2024 оны 10 сарын 26-ны өдрийн 10:30 цагт Хүрэнбулагийн рашааны хажуу талбайд нээлтээ хийн Баян-Өндөр уулыг тойрон заагдсан маршрутын дагуу зохион байгуулагдана.
2. Аялалд оролцогчид өөрсдийн судар болон Гандан хийдийн судрыг барин Баян-Өндөр хайрхныг гороолон /тойрох/ Хүрэнбулагийн рашааны дэргэдэх талбайд ирнэ.
3. Гороо аяллын зохион байгуулалтыг хамтран ажиллах байгууллагын ажлын хэсгийн бүрэлдэхүүн хариуцна.
4. Тус аялалд оролцох хүсэлтэй иргэдийг нээлттэй хамруулна.
5. Аяллын үеэр иргэдэд уламжлалт зан үйл, эрүүл мэнд, байгаль орчноо хамгаалах талаар сурталчилгааг хийх болон буяны ном хурна.
6. Тухайн орчны хогийг цэвэрлэн, байгаль орчноо сэргээнэ.
7. Нийт оролцогчдоос хамгийн ахмад, хамгийн залуу аялагчдыг шалгаруулж гарын бэлгээр урамшуулна.
8. Хөгжөөнт танин мэдэхүйн тэмцээн зохион байгуулагдан шилдэг оролцогчид гарын бэлэг, дурсгалын зүйлийг гардуулна.
9. Аялагч бүр аялалд тохирсон хувцас хэрэглэлтэй байх ба 1 өдрийн хөнгөн хүнсийг бэлтгэн авч явна.
10. Аяллын явцад аялагчдын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хариуцсан эмч ажиллах бөгөөд явган аяллын дүрэм болон зааварчилгааг явган аяллын замын хөтөч өгнө.
11. Аяллын явц үр дүн, оролцогчдын сэтгэгдэл, ач холбогдлыг үнэлсэн мэдээллийг орон нутгийн хэвлэл мэдээлэл болон цахимаар сурталчилна.
12. Тус аялалтай холбоотой мэдээллийг 99174370, 99925119 дугаараас лавлана уу.

“ЭРҮҮЛ МЭНД – ЭКО ГОРОО” аяллыг  
зохион байгуулах ажлын төлөвлөгөө

№	Зохион байгуулах ажил	Хугацаа	Хариуцах байгууллага
1	Ажлын хэсгийн уулзалт зохион байгуулах	2024.10.17	ЭМГ А.Хонгорзул Баян-Өндөр сум Ш.Алиманцэцэг
2	Гороо аяллын удирдамж · төлөвлөгөөг хэлэлцэн батлах	2024.10.17	ЭМГ БТСГ
3	Аяллын талаар байгууллага, багийн иргэдэд зар хүргэх, олон нийтийн оролцоог хангах	2024.10.18- 2024.10.26	Баян-Өндөр сумын ЗДТГ
4	Цахим орчинд иргэдэд зар хүргэх	2024.10.18- 2024.10.26	Ажлын хэсэг
5	Нээлтийн үйл ажиллагааг зохион байгуулах /Амарын талбай, хөтлөгч, техник аппаратур/	2024.10.26	Баян-Өндөр сумын ЗДТГ Соёл урлаг, аялал жуулчлалын газар
6	Яаралтай түргэн тусламж ажиллуулах	2024.10.26	БОЭТ
7	Ном судар тавих ширээ, сандал – 3, майхан барих	2024.10.26	ЭМГ
8	Зөөврийн хөгжим бэлтгэх	2024.10.26	БТСГ
9	Аялагчдад өгөх нэг удаагийн хүнс бэлтгэх, ус, ном уншлагын эхийг олшруулж хэвлүүлэх, тараах	2024.10.26	Хутагт ламын Ганданшаддүвлин хийд
10	Байгаль орчноо цэвэрлэх /нэг удаагийн бээлий шуудай/	2024.10.26	Соёл урлаг, аялал жуулчлалын газар
11	Байгаль орчноо хамгаалах талаар сургалт сурталчилгаа хийх	2024.10.26	Соёл урлаг, аялал жуулчлалын газар
12	Буяны ном хурах	2024.10.26	Хутагт ламын Ганданшаддүвлин хийд
13	Тэмцээн уралдааны шагнал гардуулах	2024.10.26	Ажлын хэсэг
14	Тайлан мэдээг нэгтгэх	2024.10.28	Ажлын хэсэг

Эрүүл мэндийн газрын даргын 2024 оны 10 сарын 21  
өдрийн тоот тушаалын хавсралт



“ЭРҮҮЛ МЭНД – ЭКО ГОРОО АЯЛАЛ”-ЫН ТӨСВИЙН ЗАДАРГАА

№	Зарцуулах төрөл	Тоо, ширхэг	Нэгж, үнэ	Мөнгөн дүн
1.	Хамгийн хамгийн шалгаруулах /ахмад, залуу, тогтмол/	3	50.000	150.000
2	Эко гороо аялал хулдаасан хэвлэл	1	100.000	100.000
Нийт 250.000				

ХЯНАСАН: ССБМНБА  
БОЛОВСРУУЛСАН: ХБӨТСХМ

  
Н.ЧУЛУУН-ЭРДЭНЭ  
А.ХОНГОРЗУЛ